

БУРИАДЫН ЭРДЭМТЭН БАГШ БАЗАР САНЖИЕВИЧ ИШДОРЖИЙГ УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДҮҮЛСЭН НЬ

Х.МЭНДСАЙХАН

Товч утга: Монгол орны тусгаар тогтнол, соёл боловсролын хөгжилд монгол угсаатнууд ялангуяа буриадууд зохих байр суурийг эзэлдэг. Тэдний нэг нь өгүүлэн буй “И” багш буюу Базар Ишдорж юм. Энэ эрхэм хүндэт хүний тухай эрдэмтэн судлаачид нэлээд өгүүллийг бичиж судалгааны эргэлтэд оруулжээ. Архивын баримтуудад болон зарим судлаачид түүнийг “И” багш, Базарын Ишдорж хэмээн бичсэн нь Ишдорж нэрээр алдаршжээ. Үнэн зөв нэр нь Базар Ишдоржийн буюу Ишдоржийн Базар юм. Энэ өгүүлэлд, түүний туулж өнгөрүүлсэн амьдрал, төрсөн газар, Германд суралцсан монгол сурагчдын багш байсан улс төрийн хэлмэгдүүлэлт өртсөн, Монголын харьяат болсон эсэх талаар тодруулахыг оролдов.

Түлхүүр үг: Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн буриадууд, Базар Санжиевич Ишдорж, Герман, Францад суралцсан монгол сурагчид.

1. Базар Ишдоржийн намтар, үйл ажиллагаа

Судлаачид, Базар Ишдоржийн төрсөн газрыг 1898 онд Өргөө хотод, 1900-иад оны орчим Буриад Улсын Сэлэнгэ аймгийн Оронгой нутагт төрсөн хэмээн хоёр янзаар бичсэн байдаг. Тагнуулын тусгай архивын хөмрөгт хадгалагдаж буй 1938 онд түүнийг улс төрийн хэрэгт байцаасан Ялагдагчийн мэдүүлэг болон судлаач Б.Д.Цибиков¹ өгүүлэлдээ, “1899 онд Буриад Монголын Автонимит Улсын Сэлэнгэ Оронгой суманд төрсөн, Оронгойн бага сургууль, Чита хотын гимназийг тус тус төгссөн² хэмээн тэмдэглэсэн байна. Тэр нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож Зүүний ардчилсан үзлийг дэмжигч байв.

Судлаач Б.Шагдаржав, Ишдоржийн Базар буюу “И” багш өгүүлэлдээ,

“Эрхүү хот дахь Коминтерны Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүн Б.Шумяцкийн оролцоотойгоор Монголын хувьсгалчидтай танилцсан нь Монгол оронтой хувь заяагаа холбохын эхлэл болжээ. Монголын хувьсгалчид 1920 оны 11 дүгээр сараас Эрхүү хотноо “Монголын үнэн” сонинг хэвлүүлж эхлэхэд сонины зөвлөлд С.Буяннэмэх, Базар Ишдорж нар ажиллаж байсан төдийгүй 1922 оны 1-р сард Москва хотноо Дорно дахины Хөдөлмөрчдийн анхдугаар их хурал хуралдахад

¹ Цибиков Б.Д., Базар Ишдоржин (Ишдорж багши), *Выдающийся бурятские деятели*, №3, Улаан-Үд, 1999, 57.

² ТЕГ-ын Тусгай Архив, Ц-250. Дело № Р-10946.

Буриадын эрдэмтэн багш Базар Санжиевич
Ишдоржийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлсэн нь

Монголын төлөөлөгчдийн орчуулагчаар ажиллаж, манай орны төлөөлөгчид
В.И.Ленинтэй уулзахад хэлмэрч хийж байсан”³

хэмээн дурссан байдаг.

Тухайн үеийн Монгол улсад ард иргэдийг бичиг үсэгт сургах, тэдний мэдлэг боловсролыг дээшүүлэхэд буриадын эрдэмтэд багагүй хувь нэмэр оруулсан байдаг. Ардын Засгийн Газраас 1922 оны 4-р сард Дотоод Явдлын Яамны дэргэд Сургуулийн хэлтсийг байгуулж⁴, 1924 онд Ардыг Гэгээрүүлэх Яам нь ерөнхий, сургуулийн, ардыг боловсруулах гэсэн 3 хэлтэстэй байгуулагджээ. Энэхүү сургуулийн хэлтэс нь бага, дунд тусгай мэргэжлийн сургуулиудыг байгуулж, түүний сурагчид, багш нарын орон тоо, төсөв зардлыг тогтоох, сурах бичиг хэвлүүлэх ажлыг хариуцаж байжээ.

1922 онд Засгийн Газрын 33 дугаар хурлаар Нийслэлд “Багш нарыг бэлтгэх сургууль” байгуулан монгол бичиг мэддэг 20-иод залуучуудыг 4 сарын хугацаагаар сургаж, бага сургуулиудын танхим нээх тухай тогтоолыг батлав⁵. Мөн онд Базар Ишдорж Сургуулийн хэлтсийн тушаалаар Монголд ирж тус бага сургуульд орчуулагчаар ажиллаж байгаад 1925 онд Улаанбаатар хотын дунд сургуулийн танхимын хэргийг захиран шийтгэх сургагчаар ажилласан байна⁶. Харин хэдэн оноос дунд сургуулийн захирал болсныг тодруулбал, архивын хөмрөгт буй 1926 оны Ардыг Гэгээрүүлэх Яамын ажилчдын бүртгэлд, “Ишдорж 27 настай, Буриад улсын харьяат, дунд сургуулийн захирал, сургагч, дунд сургуулийн байшингийн дугаар №5-д амьдармуй” гээд үргэлжлүүлэн,

“1928 оны дунд сургуульд ажиллаж буй гадаадын хүмүүсийн бүртгэлд, Базар Ишдорж ЗХУ-ын харьяат ард, 12(1922) онд Сургуулийн хэлтсийн тушаалаар ирсэн. Буриад мужийн гүйцэтгэх хорооны гишүүн. Одоо дунд сургуулийн захирал, хавсарсан сургагч. Ардыг Гэгээрүүлэх Яамны хамаарсан сайдын албыг давхарлан хашдаг. Холбоот Улсын Элчингийн Газраас олгосон үнэмлэхээр оршин суудаг. Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн гишүүн”⁷

хэмээснээс үзэхэд, 1926 онд дунд сургуулийн захирал, 1928 онд сургуулийн захирал, хавсарсан сургагчийн албыг тус тус эрхэлсэн байна. Түүнийг захирлаар ажиллаж байсан үеийнх нь тухай Д.Намдаг гуай,

“...захирал Ишдорж, сурагч бидэнд үүрд дурсагдах хүндэт багш. Магнай тэнэгэр, зүс царай тунгалаг. Дээд уруул, эрүү хоёртоо тачирхан хар

³ Шагдаржав Б, *Улс Монголынхоо төлөө*, УБ, 2011, 47.

⁴ Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. *Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал*, УБ, 1997, 216.

⁵ ГХТА(Гадаад Харилцааны Төв Архив), Х-1, Д-1, ХН-25, нуг 1.

⁶ МУУТА(Монгол улсын Үндэсний Төв Архив), МАН-ын Баримтын Төв, Х-4, Д-1, ХН-479, 36.

⁷ МУУТА, МАН-ын Баримтын Төв, Х-4, Д-2, ХН-65, ХН-66.

сахалтай. Архи тамхинаас гадуур,ажил хэрэгтнягтнямбай. Сурагч биднийг хүмүүжүүлэхдээ ширүүхэн аргыг хэрэглэдэг байсан бөгөөд түүнээс нь бидэнд муу юм болсон зүйл огтхон ч үгүй. Багш нараас өвчлөх юм уу, өөр шалтгаанаар хичээл багшгүйдэхэд Ишдорж багш орж ирэн заана.”⁸

хэмээн дурсан бичжээ.

Монгол оронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбаруудыг хөгжүүлэхэд гадаадын орнуудтай харилцаа холбоо тогтоож даашид дотоодын ихдээд сургуулиудыг байгуулахад боловсон хүчин бэлтгэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байв. Иймд 1924 оны 11-р сарын 8-нд Улсын анхдугаар их хурлаас “... аливаа дотоод, гадаадын эрдэм боловсролын сурталдулмаар дэвшүүлэн суралцуулах”⁹-аар тогтоосны дагуу Ленинград, Москва, Эрхүү хотуудад монгол сурагчдыг сургав. Улмаар Монгол Улсын 16 (1926) дугаар оны 1 -р сарын 15-нд БНМАУ-аас ЗОУ-д суугаа элчин сайд Буянчуулганаас Засгийн Газар, Ардыг Гэгээрүүлэх Яаманд Герман, Франц хоёр улсын сургуулиудад тус тус 15 хүүхэд суралцуулахаар болсон тухай мэдэгдсэн байдаг¹⁰.

Иймд Засгийн газраас хүүхдүүдийг хоёр улсад хүргэн, зохих сургуулиудад элсүүлэх, тохинуулан суулгах, мөн хэл мэдэхгүй тул урьдаар хэлний бэлтгэх хийх тусгай сургууль байгуулах, хичээлийн хэрэглэл ном, дэвтэр худалдан авах, мөн дэлхийн газрын зургийг монголчилж хувилуулах, буцаж ирэх замдаа Ленинград, Москва, Эрхүү, Үд хотуудад суралцаж буй сургуулийн монгол сурагчдын байдлыг шалган үзэх зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр Гэгээрүүлэх яамны сайд Эрдэнэбатхан, Дунд сургуулийн монгол үсгийн багш Авирмэд нарыг томилон явуулжээ.

Энэ хугацаанд Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдын албыг түр Ишдоржид хамааруулсан байна¹¹. Монгол Улсын 16 (1926) дугаар оны 11-р сарын 25-нд Эрдэнэбат сайд Герман, Францаас ирээд 11-р сарын 30-нд Засгийн Газарт,

“... Германы Берлин хотноо урьд сургуульд очоод сууж бүхий Буддарь хэмээх Дэмчигээр түр дарга орлуулсан нь тэр өөрөө сургуульд явж буй нь захирал даргын алба ажил хавсарахуй дор сургуульд суумаар байна гэх зэрэг учрыг гаргаж өөр дарга хүмүүн явуулмуй хэмээн эрсэн тухай дор ёсоор болговоос зүйтэй мэт бөгөөд дарга дор дунд сургуулийн захирал, хавсаргасан сургагч Ишдоржийг томилон явуулж Германд суулган дээд сургуульд хавсран явуулцуулж ирүүлвээс хожим манай улсад дээд сургууль байгуулахад тустай болох...”¹²

⁸ Өнөөдөр сонин, 2012.03.29, №073(4537).

⁹ БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд, УБ, 1956, 11.

¹⁰ МУУТА, Х-1, Д-2, ХН-194, 7-8.

¹¹ МУУТА, Х-1, Д-2, ХН-194, 265-266.

¹² МУУТА, Х-1, Д-2, ХН-194, 269-271.

Буриадын эрдэмтэн багш Базар Санжиевич
Ишдоржийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлсэн нь


тухай бичиг илгээсэн байна. Ингээд Монгол Улсын 16 (1926) дугаар оны 12-р сарын 2-ны өдөр Засгийн Газрын Эрхлэх товчооны гишүүдхуралдсан 234-р хурлын тогтоолын 11-р зүйлдэнэхүү асуудлыг хэлэлцээдГерман,Францын сургуульдбуй монгол сурагчдын даргадунд сургуулийн багш Ишдоржийг томилжээ¹³.

Зураг 1. Базар Ишдорж Монгол сурагчдын хамт,Берлин 1926 он¹⁴



Гадаад Явдлын Яамнаас Базар Ишдоржид гэргий Цэрэндулам, хөвгүүн Санчир нарын хамтГерман,Франц улсадэрдэм соёлын тухай хэргээр томилогдсон тул Олон Улсын нутгийн харьяат эрх баригчид ба цэрэг албаны хүмүүс найртай сайны ёсоор тусламж үзүүлж хамгаалах ажаамуу¹⁵” гэсэн дипломат хамгаалах бичиг олгосон байна.

Зураг 2. ГЯЯ-наас Базар Ишдоржийг Герман улсаявахад олгосон гадаад улсад нэвтрэх паспорт¹⁶




¹³ МУУТА, Х-1, Д-2, ХН-46, 229-230.

¹⁴ Ч.Болдын гэрэл зургийн хувийн цуглуулга.

¹⁵ ГХТА, Х-6, Д-1, ХН-72, нуг 1; ХН-73, нуг 1.

¹⁶ ГХТА, Х-1, Д-1, ХН-280.

Зураг 3. ГЯЯ-наас Базар Ишдоржийг Герман улсад явахад олгосон гадаад улсад нэвтрэх дипломат паспорт



Базар Ишдорж Германд суралцаж буй сурагчдын сургалт, амьдрал ахуй нөхцлийг хариуцахын хамтаар Монголын соёл, боловсролыг хөгжүүлэхэд шаардлагатай зүйлсийг Герман, Францад захиалан хийлгэх, худалдан авч илгээх зэрэг ажлыг гүйцэтгэж байжээ. Тухайлбал, 1927 онд Ишдоржоос Ардыг Гэгээрүүлэх Яаманд бичсэн захидалдаа "... 11 хайрцаг монгол үсгийн машин, бас 7 дугаар сарын 29-ний өдөр Ленинградаас 18 хайрцаг газрын зургуудыг..."¹⁷ илгээсэн тухайгаа бичжээ.

1926 оны 12-р сарын 9-нд Дотоодыг Хамгаалах Газраас Герман, Францад суралцаж байгаа сурагчдын ар гэрийн байдал болон сурагчдаас гадаадад суралцахад санал сэтгэгдэлийг нь нууцаар тагнаж, сурагчдын ар гэрээс сурагч Т.Нацагдоржийн гэр Амгаланбаатар хотноо 26 дугаар хувийн муу хашаатай эх Тогооч нь хөрөнгө үгүй учир ганц биеэр айл хэсүүлэн хүчин үнэлэгдэж амьдардаг. Лувсанцэндийн эх Мандах нь өөрийн хашаагүй учраас Улаанбаатар хотын 8 дугаар хороонд ахынхаа хашаанд гэр барин амьдарч байгаад хоорондоо таарч тохирохгүйн улмаас бусдын хашаанд гэр барин ганц бие амьдардаг, Батсүхийн эх Надмид 6 дугаар хороонд дунд зэргийн хашаатай 2 нях хүүхдийн хамтаар амьдардаг тухай¹⁸ мэдээллийг Засгийн газарт мэдэгдэв. Энэ талаар зохих арга хэмжээг авахаар 1926 оны 12 дугаар сарын 24-нд Засгийн Газрын 48 дугаар хурлын тогтоолоор, эдгээр сурагчдын ар гэрт "тэтгэвэр олгуулан тусламж үзүүлэхийг харьяат яамнаас эрхлэн гүйцэтгүүлэх"¹⁹-ээр шийдвэрлэжээ. Мөн энэхүү асуудлыг 1927 онд Улсын IY их хурлаар хэлэлцээд,

"Гадаадын боловсронгуй улсуудад ... бага насны сурагч хүүхдийг...

¹⁷ МУУТА, X-6, Д-1, ХН-153, 54.

¹⁸ МУУТА, X-1, Д-2, ХН-194, 282-283.

¹⁹ МУУТА, X-1, Д-2, ХН-144, 283.

явуулахыг хичээх ба явсан сурагчдын гэр газартай харилцах захидал зүйлийг саадгүйгээр нэвтрүүлэхийг... ”²⁰

тогтоосон байна. Ишдоржоос Гэгээрүүлэх яаманд Герман улсад сурч байсан сурагчдын тухай болон Монголд ирсний дараа сурагчиддаа бичсэн захидлууд, мөн Парист суралцаж байсан сурагчдаас ар гэртээ болон Ишдоржид илгээсэн нийт 74²¹ захидлууд Гадаад Харилцааны Төв Архивын хөмрөгт хадгалагдаж байна. Эдгээр захидлуудад сурагчдын суралцаж буй сургууль, тэдний ахуй хангамж, эрүүл мэнд, мөн шаардлагатай бичиг баримтын талаар бичсэн байдаг. Тухайлбал, Гэгээрүүлэх яаманд илгээсэн нэгэн захидалд, сурагч Нацагдорж, Пагмадулам нар Лейпциг хотын дээд сургуулийн дэргэдэх Дорно дахины ангид орж монгол хэл бичиг, түүх зэргийг заалгаж, улмаар дээд сургуульд дэвшин суралцахад дунд сургууль төгссөн үнэмлэх шаардлагатай болсон учир үнэмлэхийг герман ба монгол үсгээр бичиж ирүүлэхийг хүсчээ²².

1927 оны 3 дугаар сарын 28-нд Ишдорж Ардыг Гэгээрүүлэх Яаманд бичсэн нэгэн захидалдаа,

“... энэхүү Герман улсад өнгөрсөн 5 сард ирсэн 29 хүүхдийг тараан олон сургууль фабрикийн газруудад оруулан сургах явдлыг гүйцэтгэв. Өчүүхэн хүмүүний гэрийн хүмүүс энэхүү орны газар уснаа үл зохилдон өвчин ба бас өөрийн бие дор их л хүнд сэтгэлийн өвчин тохиолдон албан хэрэг явуулж чадахгүйд хүрсэн бөгөөд удтал амар үгүйгээр болсон тул даруй буцахаас өөр арга үгүй тул зүй нь эл учрыг харьяат Ардыг Гэгээрүүлэх Яамнаа толилуулан өчүүхэн хүмүүнд чөлөө олгож орон дор өөр хүмүүнийг толилон талбиж өршөөн туслах ажаамуу хэмээн үүний тул өргөв”

хэмээн Монгол руу буцах хүсэлт гаргаснаар, 1929 онд Берлингээс Улаанбаатарт ирсэн байна. Түүнийг Монголд ирсний дараа 1930 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн Төв Хороо ба Хянан Байцаах Төв Комиссын тэргүүлэгчдийн хамтарсан 50-р хурлын тогтоолоор Судар бичгийн хүрээлэнгийн гишүүнээр сонгожээ²³.

Базар Ишдорж Монгол улсын шинжлэх ухаан, боловсролын салбарт ажиллахдаа Монгол судлалыг хөгжүүлэхэд гадаадын эрдэмтэн судлаачидтай харилцаж байсан тухай баримтууд цөөнгүй байдаг. Монгол хэл бичиг судлаач энэ хүнийг нэрт эрдэмтэн Ж.Цэвээн мөн гүнээ хүндэтгэн үнэлж захидлаар харилцдаг байсан аж. Б.Ишдорж багшийг Германд байхад нь Ж.Цэвээний илгээсэн хоёр захидлыг Олон Улсын Монгол судлалын холбооноос 2008 онд эрхлэн хэвлүүлсэн “Аав хүү Рерих нар ба Монгол”²⁴ номонд нийтэлсэн байна.

²⁰ БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд, УБ, 1956, 77.

²¹ МУУТА, Х-6, Д-1, ХН-140.

²² МУУТА, Х-6, Д-1, ХН-153, 119.

²³ МУУТА, МАН-ын Баримтын төв, Х-4, Д-3, ХН-166, 148-149.

²⁴ Болд Ч. Эрдэмтэн багш Базарын Ишдорж, Өнөөдөр сонин, 2012-03-29, №073 (4537).

1928 онд Б.Котвичиос Монголын тухай Европын хэлээр хэвлэгдсэн номын жагсаалтыг Базар Ишдорж, Гомбожав нартирүүлснийг тэдхувиран бичиж Ж.Цэвээнд захидлын хамт илгээж байсан нь Монгол судлалыг хөгжүүлэхэд тэр үеийн эрдэмтэднэгдмэл нэгэн сэтгэлээр хамтран ажиллаж байсныг илтгэж байна. Тэд захидалдаа,

”... Котвичиос танай хүрээлэнгээсилгээсэн ном зэргийг хүлээн авч ихэд баярлан байдаг... бас.... Монгол газар очихыг хүсдэг...”²⁵

тухай сэтгэгдлийг нь бичиж дамжуулж байсан нь тэдний хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын шинжлэх ухааны салбарын гадаад харилцааг өргөжүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэсэн байдаг. Түүнчлэн хэл шинжлэлийн салбарт “Герман-Монгол хэлний толь бичиг” (1928), “Die Heutige Mongolei Kulturelle Aufbauarbeit in der Mongolei” нийтлэл (1929), Монгол хэлний дүрэм (1930), Монголын шинэ үсгийн заавар (1931), Унших дэвтэр (1931), Монгол үсэг хэмээх дэвтэр (1933), Монгол хэлний яруунайруулга (1934), Монгол үсгийн сурах бичиг (1936)²⁶ зэрэг олон бүтээл тууривжээ.

Мөн судлаач Ч.Болд нийтлэлдээ, “Түүний 1928 онд зохиосон “Герман-монгол хэлний толь бичиг” нь одоо Үндэсний номын сангийн сан хөмрөгт гар бичмэлээрээ хадгалагдаж буйг тэмдэглээд, тэр тухай нь Билгүүн номч Б.Ринчен гуай “...Манай Улсын номын санд 1928-1929 оны орчим хийсэн хоёрын зэрэг Европ Монгол бага шиг толь бичиг бий. Хоёулаа хэвлэгдэж чадаагүй, бичмэл эх нооргоороо байгаа нь герман, монгол хэлний толь бичгийг Ишдорж багш хийгээд, Судар бичгийн хүрээлэнгийн дуун ухааны тасагт өгсний нь номын санд хадгалуулсан...”²⁷ тухай дурсан ярьсныг бичсэн байна. Үүнээс гадна, 1930-1933 онд “Соёлын тэмцэл” сэтгүүлийн эхний 12 дугаарыг “Багш нарын сэтгүүл”²⁸ нэртэйгээр эрхлэн хэвлүүлсэн байна.

Ийнхүү Базар Ишдоржийн Монголын шинжлэх ухаан, соёл, боловсрол ялангуяа хэл шинжлэлийн салбар болон барууны улс орнуудын хөгжлийг нэвтрүүлэх, сургалтын баазыг бэхжүүлэх, ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд зориулсан нэр их хөдөлмөрийн үр дүн нь тухайн үед Герман, Францад суралцаж байсан их зохиолч Д.Нацагдорж, Д.Наваан-Юндэн, Д.Намдаг, Т.Нацагдорж зэрэг бусад хүмүүсийн зохиол туурвил бүтээсэн үйлстэй салшгүй холбоотой юм.

²⁵ Соён гэгээрүүлэгч Ж.Цэвээний захидлууд, Орчуулсан М.Д.Бадамням, редактор Ч.Нарантуяа, УБ, 2013, 71.

²⁶ Пүрэвжав Э. Монгол хэл бичгийн судлал-XI, УБ, 2008, 28.

²⁷ Болд Ч. Эрдэмтэн багш Базарын Ишдорж, Өнөөдөр сонин, 2012-03-29, №073 (4537).

²⁸ Энхзаяа Ц. Ардын гэгээрлийн тулгын чулуу тавилсан хүний нэг, Сурган хүмүүжүүлэгч №2, УБ, 1982, 74.

2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлсэн нь

Монголд 1922 оноос эхэлсэн улс төрийн хэлмэгдүүлэлт нь 1937 онд дээд оргилдоо хүрч олноор нь хомгорлон баривчлах үйл явц эхлэсэн билээ. Үүнд, Монголын төрд алба хашиж байсан болон дагаар орсон буриадууд Лхүмбийн хувьсгалын эсэргүү хэрэг, Японы тагнуул, Пан монголизмын үзэлтэн нэрээр улс төрийн хилс хэрэгт өртөв. Энэ талаар түүхч, доктор Д.Өлзийбаатар, Онон, Дадал сумын харьяат 1929 онд цэргээс оргосон Ш.Дамдин Манжуурт Японы тагнуулын албанд элссэн гэсэн цуурхал БНМАУ-д дагаар орсон буриадиргэд, Манжуур дахь Японы тусгай алба хоёрын хоорондын харилцааны гаргалгаа болж, Хэнтий аймагт ажлаар нэг хоносон МАХН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн Лхүмбийн нэртэй холбон ДХГ-ын зөвлөх Чибисовын удирдлагаар “Лхүмбийн хувьсгалын эсэргүү”, “Японы тагнуулын бүлэг” хэрэг гэгчийг үүсгэсэн нэг шалтгаан нь Коминтерн, ЗХУ-аас 1929-1932 онд Монголд явуулсан алдаатай бодлогын үр дагаварыг Монголын улс төрийн бүлэглэлд тохих замаар хариуцлагаас бултан зайлах арга ажиллагаа байв²⁹ хэмээн дүгнэжээ. Монгол, Зөвлөлтийн Засгийн Газрын хооронд 1930 оны 5 дугаар сарын 26-нд “Дагаар орогсдын асуудлын тухай хэргүүдийг нэгэн тийш болгох протокол”³⁰-ыг хэлэлцэн баталж, манай улсад 1924 оноос хойш “Дагаар орсон буриадуудыг дахин хянах, улс төр, эрүүгийн хэрэгтэн нэрийдлээр эгүүлэн татах”³¹-аар шийдвэрлэж, БНМАУ-ын харьяатаас татгалзуулсан байдаг. Улмаар 1933 оны эхээр Дотоодыг Хамгаалах Газрын ажилтнууд Улаанбаатарт зөвлөлдөж, БНМАУ-д дагаар орсон буриад иргэдийн дунд Японы гар хөл бологсдыг илрүүлэхээр тогтжээ. Энэхүү ажиллагаанд Монголын төрд ажиллаж байсан буриадууд ч өртөв. Ингэж буриадуудыг улс төрийн хилс хэрэгт татсаны учир нь, 1936 оны 11-р сарын 25-нд Япон, Германы хооронд Коминтерны эсрэг пакт байгуулагдсан нь Зөвлөлт, Японы харилцааг хурцатгах шалтгаан болжээ. Уг гэрээ бичгийн зорилго нь, Гадаад Монгол болон Хятад дахь Зөвлөлтийн нөлөөг сулруулах, тэнд улааны суртал ухууллагатай тэмцэхэд оршиж байв.

Японы аюулыг тун ноцтой гэж үзэж байсан Сталин 1936 оны 3-р сард дуулгаваргүй Гэндэнг зайлуулж, БНМАУ-ын удирдлагаар Зөвлөлтийн талыг баримтлагч Х.Чойлбалсанг томилжээ. Японы арми 1937 оны 8-р сард Датун, 9-р сард Жанчхүүг эзэлсэн нь БНМАУ-ын өмнөд хил ойртож нэг бол БНМАУ-д цөмрөх эсвэл баруун хойд Хятадад цөмрөх аюултай боллоо гэж Зөвлөлтийн армийн удирдлага тооцоолсон байна. Иймд БХК(б) Намын УТТ, БНМАУ-д Зөвлөлтийн томоохон анги нэгтгэлийг илгээх шийдвэрийг 8-р сарын 13-нд гаргажээ. Тэд

²⁹ Өлзийбаатар Д. *Яагаад 1937 он?..* УБ, 2004, 183.

³⁰ Мэндсайхан Х. Дагаар орсон буриадуудыг “Лхүмбийн хэрэг”-т холбогдуулж БНМАУ-ын харьяатаас татгалзуулсан нь. Лхүмбэ-80, УБ, 2013, 103.

³¹ Алтанхуяг А. Улс төрийн хэлмэгдүүлэлтийг төв хүрээний харилцан хамаарлын үүднээс авч үзэх нь, Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгалын симпозиум, УБ, 2005, 38-39.

“БНМАУ-ыг булаан эзлэх Японы төлөвлөгөө” гэсэн зүйлийг шалтаг болгон 8-р сарын 24-нөөс эхлэн 30 орчим мянган хүнтэй Зөвлөлтийн 17 дугаар армийг БНМАУ-д оруулж Монголын өмнөд болон зүүн өмнөд хилээр төвлөрүүлэн байрлуулав.

Уг цэргийн орох асуудлыг газар дээр нь удирдахаар БХАК-ын орлогч Смирнов 8-р сарын 24-нд Улаанбаатарт иржээ. БНМАУ-д цэрэг оруулахтай нэгэн зэрэг Монголд өргөн хэмжээний баривчилгаа явуулах шийдвэрийг ЗХУ-ын удирдлага зөвшөөрч, ДХАК-ын орлогч Фриновский энэ үүргийг авч Смирнов нартай нэгэн зэрэг 8-р сарын 24-нд Улаанбаатарт ирэв. Фриновский БНМАУ-д буй Японы хуйвалдааны толгойлогч хэмээн 115 хүний нэрсийг авчирч 9-р сарын 10-ны шөнөөс эхлэн Монголд хүмүүсийг үй олноор нь баривчлах үйл ажиллагааг эхлүүлсэн³² байдаг. Энэхүү 1937 оны баривчилгаа нь юуны өмнө Ерөнхий сайд Гэндэн, Бүх Цэргийн жажин Дэмид нарын удирдсан “Японы тагнуулын бүлэг” хэмээн зохиомол хэрэг үүсгэж тэдний хамсаатан хэмээн МАХН-ын Төв Хороо болон Армийн дээд командлалын олон хүмүүсийг татан оруулж хэлмэгдүүлсэн юм.

1937 оны 3 сард ДХАК-ын дарга Ежов, түүний удирдлагад байсан ажилтнууд Япон-Буриадын хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллагын төв”-ийн зохиомол хэргийг бэлтгэж хэдхэдэн хотод баривчилгааг эхлүүлэв. Үүнд, 1937 оны 8-р сарын 7-нд ЗХУ-ын ШУА-ийн аспирант М.Гомбожавыг хэрэгт тулган хүлээлгэж таслан шийдвэрлэх арга хэмжээ авах тухай тогтоолыг Ленинград мужийн ДХАК-ын удирдах газрын дарга гаргасан байдаг. Уг тогтоолд, түүнийг шинээр илэрсэн Японы тагнуулын хорлон сүйтгэх, эсэргүү байгууллагын гишүүн болох нь нотлогдсон тул ЗХУ-ын Эрүүгийн хуулийн 58-6, 9, 11-р зүйлээр хэрэгт татан тусгаарлан хорьжээ. Байцаалтын явцад, Гомбожав өөрийн танил хамтран ажиллаж байсан болон багш шавийн барилдлагатай олон хүний нэрийг мэдүүлсний дотор 1923 онд Базар Ишдоржтой Монголд танилцсан, одоо Гадаад хэвлэлийн редактороор ажилладаг гэж хэлжээ. Мөн Ишдоржтой холбогдож буй Ринчино Элбэгдоржтой

1924 оноос Монголд танилцсан, 1924 оноос Ринчин Бямбаевтай тус тус танилцсан талаар мэдүүлсэн байна³³. Энэхүү мэдээллийн дагуу 1938 оны 5-р сарын 12-нд Базар Ишдоржийг хувьсгалийн эсэргүү улс төрийн хэрэгтнээр баривчлан хорив. Түүнийг ийнхүү хилс хэрэгт ял тулгасныг Тагнуулын Тусгай Архивын Архивын хөмрөгт буй түүнийг байцаасан хавтаст хэргийн яллах дүгнэлтэд тэмдэглэсэнээр,

³² Батбаяр Ц. *Монгол ба Япон XX зууны эхний хагаст*, УБ, 1998, 112, 113.

³³ *Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоо*, ХҮП боть, Зохиогч С.Туяа. УБ, 2013, 120-125.

“Хөрөнгөтний үндсэрхэг үзэлтэн Ишдорж нь Пан монгол үзлийг номлогч, тухайн үед Дорно дахины тасагт ажиллаж байхдаа Элбэгдорж Ринчинотой холбоотой байсан. ИККИ-гийн Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар нь Зөвлөлт Засгийг устгах Пан монгол үзлийг дэлгэрүүлэх Японы талыг баримтлах зорилготойгоор байгуулагдсан. 1922 онд Базар Ишдорж нь тухайн үед БНМАУ-ын зөвлөхөөр ажиллаж байсан Элбэгдорж Ринчиновын урилгаар Монголдожиж хуучны хэлхээ холбоогоо сэргээн түүнийг Пан монгол үзэлтэй Зөвлөлт Засгийг илэрхий үзэн яддаг, үндсэрхэг үзэлтэн гэдгийг Ринчинов мэдэхийн хувьд нэгэн удаа уулзаад тухайн үед Улаанбаатарт байгуулагдсан Пан монголыг байгуулах хөрөнгөтний үндсэрхэг тагнуулын байгууллагадаа элсүүлэх санал тавьсан. Тэгээд Базар Ишдоржийг зөвшөөрөхөөр нь хувьсгалын эсэргүү, тагнуулын байгууллагын хорлон сүйтгэх ажиллагааг Японы тусын тулд гүйцэтгэх даалгавар өгсөн. Базар Ишдорж дунд сургуулийн хичээлийн эрхлэгч байхдаа албан тушаалаа ашиглан Пан монгол үзлийг шүтэх болон БНМАУ-д бий болоод байсан нийгмийн байгууллыг эсэргүүцэх үзлийг шавь нартаа номлосон. Тэр үед сургуулийн багш нар нь гадны улс байсан. Тухайлбал, Дашиев, Тугулханов нар цагаач, Эрхэмбат, Раш хоёр Японы тагнуул, Магсаржав, Авирмэд хоёр том толгой феодал төдийгүй хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллагадаа гишүүн элсүүлэх ажлыг идэвхитэй хийж байжээ. Мөн хэвлэлийн газрыг дэлбэлэх ихээхэн өргөн хүрээтэй хорлон сүйтгэх ажиллагааг төлөвлөж байв. Түүгээр ч зогсохгүй Гэгээрлийн яамны сурах бичгийн редактороор ажиллахдаа сургуулиудад зайлшгүй хэрэгтэй сурах бичгүүдийн хэвлэлтийг санаатайгаар саатуулан хойшлуулсан. Марксизмын сонгодог бүтээлүүдийг орчуулахдаа утга санааг нь зориудаар гажуудуулж хувьсгалч үзэл санааг нь бүдгэрүүлж байсан. Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв Хорооны нууц тогтоол шийдвэрүүдийг Ринчино түүнд дамжуулдаг байсан. 1936 онд Москва руу явахын өмнө Ринчин Бямбаевын байгууллагаас тагнан турших хорлон сүйтгэх алан хядах даалгавар авсан. Москвад очоод гадаад ажилчдын хэвлэлийн газрын монгол хэлний тасагт орчуулагчаар ажиллахдаа Ринчинотой холбоо тогтоож хувьсгалын эсэргүү тагнан турших, алан хядах Японы талыг баримтлагч бүлэгтээ хүмүүсийг элсүүлэх даалгаварыг байнга авч байсан. Дээрх дурдсан гэмт хэргүүдийг үйлдсэн гэдгийг үндэслэн 1899 онд төрсөн Буриад Монголын Автономит Улсын харьяат, ЗХУ-ын иргэн нам бус, эхнэртэй, цэргийн алба хаагүй, өмнө ял шийтгэлгүй, 1927-1929 онд Германд ажиллаж байсан, амьдралын боломжгүйгээс дээд сургуулийг төгсөж чадаагүй, 1936 онд ЗХУ-д эргэж ирсэн, баричлагдахаасаа өмнө НКПС-ын дэргэдэх Техникийн курсэд орчуулагчаар ажиллаж байсан Базар Ишдоржийг, Хувьсгалын эсэргүү, тагнан турших хөрөнгөтний үндсэрхэг үзэлтэн, хорлон сүйтгэх тэсэлж дэлбэлэх үйл ажиллагааг үйлдсэн, тагнуулын байгууллагадаа элсүүлэх зорилгоор хүмүүсийг талдаа татаж байсан; 1936 онд ЗХУ-д ирэхээсээ өмнө Ринчин Бямбаевын тагнуулын байгууллагаас алага хядлага үйлдэх

нууц даалгавартай ирсэн; Москвад байхдаа тагнуулын мэдээ цуглуулсан учраас ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1, 58-8 зүйл ангиудад заасан алан хядах байгууллага байгуулах зорилгоор хүн элсүүлж байсан хэрэгт буруутгаж, 1934 оны 10 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон хуулийн дагуу ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн мэдэлд шилжүүлсэн. Яллагдагч Базар Ишдорж нь 1938 оны 12 дугаар сарын 28-наас хойш Бутырийн шоронд хоригдож байгаа. Хэрэгт холбоотой эд мөрийн баримт байхгүй”³⁴

хэмээн бичсэн байна. Дээрх баримтаас зарим зүйлийг тодруулья. Базар Ишдорж нь 1936 онд Монголоос ЗХУ руу хэрхэн учир явсан тухай баримт олдоогүй байна. Гэхдээ 1923 оны 5-р сарын 19-нд Монгол Газар бүхий Буриад Монголын Хэргийг Эрхэлсэн хурлын газарт Зөвлөлийн Засагт Орос Улсын харьяат Буриад Монголын Автономит мужийн хэргийг эрхлэн захирах коминдатын газраас илгээсэн бичигт,

“ ... манай газарт монгол бичиг үсэг дор боловсон хүмүүн нар цөөн болох тул ... манай газраас түр томилогдон одсон Ишдорж дор олгосон хугацаа нэгэнт өнгөрсөн... тул түүний биеийг манай газраа эгүүлэн ирүүлэх...”

гэжээ. Үүний хариуд,

“Монголын Засгийн Газраас Буриад Монголын Автономит мужийн коминдатын газраас зөвшөөрлийг авч сургагч Ишдоржийн биеийг урин ирүүлж... энэ оны цагаан сарын шинийн нэгнээс эхлэн дунд сургууль нээн байгуулж... Ишдоржийг Захиран хавсаргасан сургагчийн албанаа томилон суулгаснаас хойш анх удаа хоёр сургуулийн хөвгүүд цөм хүмүүжин боловсорч хүмүүн газрын хэв суртал найрамдан нийлэлцээд харилцан хэлэлцэхүй дор татгалзалтай зүйл бүхий дээр сургагч, багш Ишдорж нэгэнт үүсгэн сургасан сургуулийн хэргээ төгсгөх хүсэлтэй тул хэдий Ишдоржийг дуудуулсан боловч тэдний мужийн газар оронд боловсорсон хүмүүс олон тул Ишдоржийн оронд тэндээс өөр хүмүүн суулгаваас болох үгүй газар үгүй...”³⁵

хэмээн илгээсэн байдаг. Иймд тэр Монголын боловсролын салбарт эхлүүлсэн ажлынхаа үр дүнг үзэхээр 1926-1929 онд Герман, Францад улсуудад монгол сурагчдын багшаар ажиллаж ирсэний дараа Судар бичгийн хүрээлэн зэрэг шинжлэх ухаан, боловсролын салбаруудад 1935-1936 он хүртэл ажиллаж байгаад буцсан бололтой.

Нөгөө талаар, зарим судлаачид Базар Ишдоржийг 1937 онд нас барсан хэмээн бичсэн нь бий. Энэ талаар тодруулбал, түүнийг байцаасан хэргийн баримтад “1938 онд Бутырийн шоронд хоригдож буй” гэсэн нь 1937 онд амьд

³⁴ ТЕГ-ын Тусгай Архив, Ц-250, Дело № Р-10946.

³⁵ МУУТА, Х-1, Д-1, ХХ-179, 25-26.

сэрүүн байсныг батлах юм. Базар Ишдоржийг улс төрийн хилс хэрэгт ялласан Эрүүгийн хуулийн 58-1(а) зүйлд,

“Эх орноосоо уравсан... улсын бүрэн эрхт болон нутаг дэвсгэрийн халдашгүй байдалд хохирол учруулахыг тулд тагнуул үйлдсэн, цэргийн болон улсын нууцыг гадаад улсад өгсөн, дайсны талд урван орсон, хил давж оргосон... бол буудан алж бүх хөрөнгийг нь хураах, хөнгөлөх шалтгаантай бол 10 жил хүртэл хорих”³⁶

гэж заасны дагуу “буудан алж, хөрөнгийг нь хураах” ялаар шийтгүүлснийг 1958 оны 5-р сарын 27-нд түүний хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай ЗХУ-ын Дээд Шүүх, Прокурорын дүгнэлт гарсан байдаг. Харин хэдэн онд түүний амийг хороосон тухай баримт олддоогүй байна. Мөн түүнийг Германд монгол сурагчдын багшаар явахад Гадаад Явдлын Яамнаас олгосон паспортад “Төрсөн газар: 1899 онд Улаанбаатарт” хэмээн бичсэн байна. Бид энэ талаар тодруулахаар түүнийг Монголд ажиллах хугацаандаа тус улсын харьяат болохыг хүссэн болон харьяат иргэн болсон тухайд сурвалжилсан боловч нотлох баримт хараахан олддоогүй юм.

Базар Ишдоржтой тухайн үед Монголын төрийн алба хашиж байсан буриадууд тухайлбал, Цэвээн Жамсранов 1925 онд Монголын харьяат болсон³⁷ бөгөөд түүнийг 1929 онд барууны үзэлтэн хэмээн МАХН-аас хөөж, 1937 онд улс төрийн хилс хэрэгт баривчлан 1940 оны 5 жилийн ял оногдуулан ЗХУ-ын Соль Глецийн шоронд хорьсон байдаг.

Бид Базар Ишдоржийг Монголоос ЗХУ-дочсоны дараа ДХАК-ын дарга Ежов, түүний удирдлагад байсан ажилтнууд баривчилсан тухайд дээр өгүүлсэн. Түүнийг Элбэгдорж Ринчино, Ринчин Бямбаев нартай холбоотой төдийгүй тэдний даалгавараар хувьсгалын эсэргүү хорлон сүйтгэх ажиллагааг гүйцэтгэсэн хэргээр ялласан байна.

Бид хэргийн мөрөөр зарим зүйлийг тодруулах зорилгоор Элбэгдорж Ринчино, Ринчин Бямбаев нарын байцаагдсан хавтаст хэргийг үзвэл, түүнтэй холбоотой мэдүүлэг байсангүй, харин Элбэгдорж Ринчино өөрийгөө,

“Би 1919 онд хувьсгалын эсэргүү Пан монголизмын үйл ажиллагаанд оролцсон. Энэ группт Барадин Базар, Жамцарана Цыбен, Сампилон Даши, Вампилон Барятон, Цыдыпов Цеден-Еши, Дылыков Намдан, Бимбаев Раднажап, Баумажанов Цокто, Галсанов Жигжат, Тугултуров Аюши, Богданов Михиал, Цибиков Гомбоджал, Дамдинов Найдан...”³⁸

зэрэг хүмүүс байдаг тухай мэдүүлсэн байна. Мөн түүнийг “1936 онд ЗХУ-д

³⁶ Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгал цагаан ном, УБ, 1993, 127.

³⁷ МУУТА, Х-41, Д-1, ХН-452, 1, нуг 2.

³⁸ ТЕГ-ын Тусгай Архив, Ц-37, Уголовное дело.

ирэхээсээ өмнө Ринчин Бямбаевын тагнуулын байгууллагаас аллага хядлага үйлдэх нууц даалгавар авсан” хэмээн тодорхойлсон байна. Энэ талаар тодруулбал, Ринчин Бямбаевыг 27 буюу 1937 оны 9-р сарын 17-ны өдөр байцаахдаа,

“Пан монголизмын ба япон тагнуулын хэрэгт идэвхтэйгээр оролцож байсан тухайгаа хүлээж мэдүүлснээ одоо дахин батлах уу? гэж асуухад, миний бие энэ мэдүүлгийн дотор дурдсан зүйлүүдийг огтхүлээж батлахгүй, миний бие 1937 оны 9 дүгээр сарын 10-ны шөнө тус Дотоод яаманд баривчлагдан ирэхэд ... сургагч Антивинкогоос байцаасан бөгөөд ... миний таних хүмүүсийг асууж ... дараа нь Японы тагнуулын этгээдхэмээн намайг ... тулган өдөр шөнийн цагт нойр, хоол, амралтгүй үргэлжлэн зодож бүтэн хоног байцаасан. Үүнд, би тэсвэрлэхгүй болж байцаагчийн шаардлагыг дагаж хэсэг амарч түр хоол унд идэхийг хүсч Худалдаа, Тээврийн яамны орчуулагч Галзутовын Галунаар 26 (1936) онд элсэгдэж эсэргүү байгууллагад оролцсон хэмээн мэдүүлсэн, тэгэхэд байцаагч Антивинкогоос чиний бие заавал дээр үеэс эхлэн япон тагнуулд биеэр элсэгдсэн байх хэрэгтэй...”³⁹

хэмээн тулган хүлээлгэсэн тухайгаа мэдүүлсэн байдаг. Мөн Ринчин гуайтай судалгаа шинжилгээний ажлаар холбоотой байдаг Улаанбаатар, Улаан-Үд, Москва, Ленинград, Францын Парис, Германы Берлин хотуудад байдаг хүмүүсийн нэрийг асууж, тэднийг тагнуулын нууц байгууллагын гишүүд хэмээн гүтгэн баривчилсан байна. Эдгээр хүмүүсийн заримыг дурдвал, Улаанбаатар хотоос Галун Газутовын, Дэмчигийн Буддарь, Буянчуулган, Буяннэмэх, Соёлтой, Шагж, Аюушийн Сэнгэ, Дашням, Францын Парис хотоос мэргэн гүн Гомбожав, Германы Берлин хотоос Нацагдорж зэрэг хүмүүс байв. Харин энэхүү нэрсийн жагсаалтанд Базар Ишдоржийн нэр дурдагдаагүй байна.

1938 оны 4-р сарын 28-нд Базар Ишдоржийг байцаасан мэдүүлэгт Пан монголизмын тухай болон Элбэгдорж Ринчино, Ринчин Бямбаевын тухай огт дурдагдаагүй бөгөөд түүнээс Германд ажиллаж байсан тухай, мөн түүний таньдаг хүмүүсийн нэрсийг асуусан⁴⁰ нь тэднийг түүний хамсаатан болгохоор бэлтгэж байсан гэхэд хилсдэхгүй бизээ.

Мөн Германд суралцаж байсан сурагчдыг “Германы тагнуул” гэсэн хэргээр баривчилж ялласан байдаг. Тэднийг ийнхүү буруутгах болсон шалтгаан нь, 1941 онд 6-р сарын 22-нд Герман улс харилцан үл довтолцох тухай гэрээгээ зөрчин ЗХУ-д гэнэт довтолсныг далимдуулж Коминтерны тулгалтаар тэднийг “Фашист Германы тагнуул”-ын хэрэг үйлдсэн гэсэн хилс хэрэгт гүтгэжээ. Улмаар 1943 онд Герман улсыг магтдаг, тэндэхийн тагнуулын байгууллагатай холбоотой гэсэн хэргээр Н.Бат-Очирыг 25 жил, Д.Наваан-Юндэнг 20 жил, Т.Нацагдоржийг 10

³⁹ Дүйнхэржав Г. *Тамын тогоонд таван жил*, УБ, 1991, 56.

⁴⁰ ТЕГ-ын Тусгай Архив.Ц-250, Дело № Р-10946.

жил, Д.Намдагийг 7 жил, Д.Гомбыг 8 жил, Г.Цэвээнийг 7 жил, С.Лхүндэвийг 3 жил хорихоор шийтгэж, С.Бавуу, Б.Доржсүрэн, Ц.Бадарч, Ш.Цэвэг, М.Гомбожав нар⁴¹-ыг ял холбогдолгүй болгон сулласан байна.

1960-аад оны эхээр Цагаатгах ажил эрхлэх комиссыг даргалж байсан Т.Гэндэн Германы тагнуулын хэрэг нь “... шалгалтын явцад Германы Аюулаас Хамгаалах байгууллагаар шалгуулахад бодитой баримт илэрсэнгүй. Уг хэрэг хэд дахин задарсан”⁴² гэж мэдэгдсэн байдаг.

1952 оны 1-р сарын 26-нд БНМАУ-ын Засгийн Газрын Ерөнхий сайд Х.Чойбалсан, 1953 оны 3-р сарын 5-нд ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга И.В.Сталин нар нас барснаар тэдний дарангуйлан захирах хатуу дэглэм нуран унаж, ЗХУКН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн даргаар Н.С.Хрущёв сонгогдов. Түүний санаачлагаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл хэрэг ЗХУ ба БНМАУ-д нэгэн зэрэг эхэлжээ.

1956 оны 2-р сарын 25-нд ЗХУКН-ын ХХ их хурлын хаалттай хуралдаан дээр Н.С.Хрущёв “Нэг хүнийг тахин шүтсэн хийгээд түүний хор уршгийн тухай” илтгэхдээ, “... нэг хүнийг тахин шүтэхийн муу үр дагавар болж удаан хугацаанд хуримтлагдсан ... явдлыг эцэст нь хүртэл хийх явдал чухал” хэмээн улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг уудлан арилгах зорилт дэвшүүлсэн байна.⁴³

Энэхүү ажлын хүрээнд хэлмэгдсдийг цагаатгах ажил эхлэснээр, 1958 оны 5-р сарын 27-нд ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Зөвлөлийн дарга, Цэргийн Шүүхийн хошууч генерал Лихачев, гишүүдэд Цэргийн шүүхийн дэд хурандаа Демидов Иванов нарын бүрэлдхүүнтэйгээр Базар Санжиевич Ишдоржийн хэргийн талаар хуралдаж, Цэргийн Ерөнхий Прокурорын дүгнэлтийг гаргажээ.

Уг дүгнэлтэд, Базар Ишдоржийг 1922 оноос эхлэн Пан монгол үзлийг сурталчилагч, хөрөнгөтний үндсэрхэг үзэлт, алан хядах тагнуулын байгууллагын идэвхтэй гишүүн уг байгууллагынхаа даалгавраар Японы тагнуулын байгууллагын эрх ашигт нийцүүлэн тагнан туурших, хорлон сүйтгэх ажиллагаа үйлдэж байсан хэмээн буруутгагдаж, ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Зөвлөлөөс ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1а, 58-8, 58-11, зүйл ангиудаар яллагдаж, буудан алах, хөрөнгийг нь хураах ялаар шийтгүүлсэн хэргийг өнөө цагт шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан нэмэлт мөрдөн байцаалт явуулж, Ишдоржийг үндэслэлгүй ялласан болох нь тогтоогдсон тул түүнд тулгасан ялыг хүчингүй болгож гэмт хэргийн бүрэлдхүүнгүй тул энэ хэргийг хаахыг хүссэнээр, ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Зөвлөлийн 1938 оны 9-р сарын 17-ны өдрийн ялыг хүчингүйд тооцож гэмт хэргийн бүрэлдхүүнгүй хэмээн хэргийг хаасан байна.

⁴¹ Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн Судалгааны төвийн архив, Х-2, Д-1, ХН-20, 10.

⁴² Ринчин М. *Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал*, УБ, 2000, 53.

⁴³ Мөн дээрх, 69-70.

ЗХУ, Коминтерны шахалтаар хэрэгжсэн улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад Цагааны оргодол, Японы тагнуул гэгдэж буриад, орос 2100 гаруй, Гоминдан, Японы тагнуулын хэргээр 2200 гаруй⁴⁴ хүн тус тус баривчлагдан ялагджээ.

1935-1945 онуудад Дээд Шүүхийн Таслах Газраас Япон тагнуулын хэрэгт 471⁴⁵ хүн ял шийтгэгджээ. Үүнийг он дараалалаар нь ялгаварлавал дараах хүснэгт болно.

Хүснэгт 1.

Он	1935	1936	1937	1938	1939	1940	1941	1942	1943	1944	1945
Хэлмэгдсэн хүний тоо	1	37	102	7	44	22	13	45	31	77	85

1990 оны 6-р сарын 20-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 41-р тогтоолоор, Улс төрийн Товчооны комиссыг Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн комисс болгон бүрэлдхүүнийг өөрчилжээ. Энэ комисс 1930-1955 онд улс төрийн хилс хэрэгт бүгд 35744 хүн шийтгэгдсэнийг тогтоожээ.

Дүгнэлт

Дээр өгүүлсэнийг дүгнэвэл дараах мэт.

Базар Санжиевич Ишдоржийг 1938 онд хөрөнгөтний үндсэрхэг үзэлтэн, алан хядах тагнуулын байгууллагын идэвхтэй гишүүн, Японы тагнуулын байгууллагын эрх ашигт нийцүүлэн тагнан турших, хорлон сүйтгэх ажиллагааг үйлдсэн, дунд сургуулийн хичээлийн эрхлэгч байхдаа албан тушаалаа ашиглан Пан монгол үзлийг шүтэх болон БНМАУ-д бий болоод байсан нийгмийн байгууллыг эсэргүүцэх үзлийг шавь нартаа номлосон гэсэн зохиомол хэрэг үүсгэж буруутгтан буудан алж, хөрөнгийг хураан ялласан нь 1930 онд ЗХУ, БНМАУ хоёр улсын Засгийн Газрын хооронд байгуулсан “Дагаар орогсдын асуудлын тухай хэргүүдийг нэгэн тийш болгох протокол”-ын хүрээнд гүйцэтгэсэн Монголд дагаар орсон болон албан хэргээр ажиллаж байсан буриадын сэхээтэнүүдийг улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлэх ажлын хэрэгжилт байв. Түүнийг хэрэгт татахдаа Элбэгдорж Ринчино, Ринчин Бямбаев нарын хамсаатан болгосон нь тэдний мэдүүлэгт Базар Ишдоржийн нэр огт дурдагдаагүй нь түүнд тулгасан хэргийг үйлдээгүй болохыг баталж байна. Ийм ч учраас түүнийг 1958 онд ЗХУ-ын Дээд Шүүхээс цагаатгасан байна.

Герман, Франц зэрэг бусад орнуудад шинэ цагийн боловсон хүчнийг бэлтгэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн төдийгүй түүний зохиосон “Монгол хэл сурах бичиг”, “Герман-Монгол хэлний толь бичиг” зэрэг олон бүтээлүүд нь хэл шинжлэлийг хөгжүүлэхэд үнэтэй нэмэр оруулжээ.

⁴⁴ Ринчин М. *Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал*, УБ, 2000, 143.

⁴⁵ ГХТА, Х-59, Д-1, ХН-27, 27.

Abstract: Bazar Sanjievich Ishdorj was born in Selenge-Orongoy County of Buriat-Mongolian Autonomous Region, 1899. He had completed a Primary School of Orongoy and Gymnasium of Chita City. He was a holder of Russian Democratic View of East Wing and active in social and political activities. He had been working in Mongolian Education field since 1922. He had been a school director as well as trainer for Mongolian teachers from 1926 up to 1928. In 1926, He was sent to the West as a head master of Mongolian students in Germany and France by Decree of the 234th Meeting of Mongolian Government. He came back to Ulaanbaatar from Berlin in 1929. Bazar Sanjievich Ishdorj was executed under false political case, in which he was accused for advertizing Pan Mongolian ideology, nationalist pro Capitalism, member of a terrorist intelligence organization, acting as a spy for Japanese Intelligence Organization and squandering activities; specially for advertizing Pan Mongolian ideology as well as opposing views about present social institutions of People's Republic of Mongolia to school children when he was a program manager of school, in 1938. It is proven that he was libeled under political repression as we go through criminal cases of Elbegdorj Rinchino and Rinchin Byambayev and other related documents. Bazar Ishdorj was redressed by The Supreme Court of USSR in 1958. He was working for uplifting Mongolians' literacy and introducing world culture and education in Mongolia. He contributed a lot towards educating future Mongolian human resources by his publication in Linguistics such as a German Mongolian Dictionary and service as a head master of Mongolian students in Germany and France.